



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №6

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2024 оны 11 сарын 05 наас 12 сарын 05 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2024 оны 11 сарын 05 наас 12 сарын 05 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6, H3N8, H3N2, H7N9, H6N1, H10N8, H7N4, H5N8, H9N2 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тохиолдол 1: АНУ улсын Орегон мужид шувууны аж ахуйд ойр ажилладаг ажилтан өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5 хэвшинжээр өвчилсөн. Тухайн бүс нутагт тэжээвэр шувуудын дунд өвчлөл бүртгэгдэж байсан ба өвчтөнд ханиадны анхны шинж тэмдэг илэрч эдгэсэн. <https://www.cdc.gov/bird-flu/spotlights/h5n1-response-11152024.html>

Тохиолдол 2: Канад улсын нийтийн эрүүл мэндийн газар 2024 оны 11 сарын 14 нд хүний өвчлөлийн 1 тохиолдол батлагдсан тухай мэдээлсэн. Халдварын эх уурхай одоогоор тодорхойгүй байгаа бөгөөд АНУ-д бүртгэгдсэн шувууны томуугийн дэд хэвшинжээс өөр буюу нүүдлийн шувуудаас илэрдэг хэвшинжтэй ижил байна. Хэв шинж, генийн дарааллыг тогтоох судалгаан дээр үндэслэж, шувууны томуугийн вирус хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хүний халдварын тохиолдол нэмэгдэх эрсдэлтэй байгаа тухай анхааруулсан. [Canadian probe into teen's critical H5N1 infection finds no clear source | CIDRAP](#), www.nature.com

Тохиолдол 3: Вьетнам улсын Лонган мужид өндөр хоруу H5N1 вирусийн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн тухай 12 сарын 04 нд мэдээлэв. Тухайн өвчтөний гэр бүлийн шувууны аж ахуйн шувууд олон тоогоор үхсэн боловч энэ тухай орон нутгын мэргэжлийн байгууллагад мэдээлээгүй байна. <https://flutrackers.com/forum/forum/asia/h5n1-h5n8-h1n08-tracking/vietnam-aa/1001677-vietnam-long-an-detects-1-case-of-influenza-a-h5n1-infection>

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2024 оны 11 сарын 05 наас 12 сарын 05 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Австри, Чех, АНУ, Герман, Унгар, Итали, Канад, Япон, Вьетнам, Польш, БНСУ, Их Британи зэрэг 31 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 686 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу). Ихэвчлэн нүүдлийн шувууд (нугасны төрлийн шувууд), шувууны аж ахуй (тахиа,

нугасны аж ахуй), тэжээвэр амьтад болох үхэр, муур зэрэг амьтдын дунд өвчлөл бүртгэгдсэн.


Олон улсын хэмжээнд 1997 оноос хойш шувууны томуу өвчнөөр нийт 900 орчим хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдсэн. Ихэвчлэн үхсэн, өвчилсөн шувууны аж ахуйн шувуудтай ойр ажиллаж амьдардаг хүмүүс байсан бол АНУ-д 2024 онд нийт 53 хүний өвчлөл бүртгэгдсэн ба ихэвчлэн тэдгээр хүмүүс сүүний чиглэлийн үхрийн фермд ажилладаг байсан.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	Австри	Гунгар хун, тахианы аж ахуй, тогоруу, шонхор, сар, галуу, нугас	51
H5N1	Болгар	Тахианы аж ахуй	1
H5N1	Канад	Цахлай, Шувууны аж ахуй, Хүний өвчлөл	22
H5	Колумба	Шувууны аж ахуй	1
H5N1	Хорват	Нүүдлийн шувууд	1
H5, H5N1	Франц	Шувууны аж ахуй, тогоруу, цахлай	7
H5N1	Чех	Тахианы аж ахуй	11
H5N1	Герман	Тахианы аж ахуй, нугас, хун	24
H5N1	Хонгконг	Нугас	1
H5N1	Унгар	Шувууны аж ахуй, галуу, тагтаа	137
H5N1, H5N5	Исланд	Цахлай, хэрээ	4
H5N1	Итали	Гогой, галуу, нугас, шувууны аж ахуй	34
H5N1	Япон	Тогоруу, хун, нугас, шонхор, хэрээ, шувууны аж ахуй	57
H5N1	Молдав	Шувууны аж ахуй	1
H5N1	Недерланд	Шувууны аж ахуй	1
H7N6	Шинэ Зеланд	Шувууны аж ахуй	1
H5N1	Хойд Македони	Шувууны аж ахуй, нугас	2
H5N5	Норвеги	Хэрээ	1
H5	Перу	Шувууны аж ахуй	1
H5N1	Польш	Тахианы аж ахуй, нугас, хун	21
H5N1	Португал	Шувууны аж ахуй	1
H5N1, H5N3	Өмнөд Солонгос	Нугас, шонхор	7
H5N1	Румин	Тахианы аж ахуй, хун	2
H5N1	Словиан	Хун, галуу, нугас	18
H5N1	Испани	Цахлай, <i>Morus bassanus</i>	5
H5N1	Швейцар	Гунгар хун	1
H5N1	Тайвань	Халбан хошуут, шувууны аж ахуй	4
H5N1	Турк	Шувууны аж ахуй	
H5N1	Их Британи	Элээ, сар шувуу, шар шувуу, цахлай	14
H5N1	Украйн	Шувууны аж ахуй	4
H5N1	АНУ	Үхрийн ферм, шувууны аж ахуй, хүний өвчлөл, орчны гадаргуугаас авсан дээжнээс	236
H5N1	Вьетнам	Шувууны аж ахуй, хүний өвчлөл	4

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 1. 2024 оны 11 сарын 05 наас 12 сарын 05 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Шувууны аж ахуй эрхлэгчид:

- Гадаад орчноос халдвар дамжин ирэх эрсдэлийг бууруулах зорилгоор зайлшгүй нэврэх ажилчид, техник хэрэгслийн жагсаалт гаргаж, нэвтрүүлэх
- Халдвар хамгааллын дэглэм мөрдөх буюу шувууны байранд орох болон гарахдаа гутлаа тогтмол цэвэрлэх, гараа тогтмол савандаж угаах, техник хэрэгслийн дугуйг халдваргүйжүүлэх
- Шувуудыг нүүдлийн шувууд болон төв суурин газрын бусад шувуудаас тусгаарлах
- Тэжээвэр шувууг худалдан авах, зарахдаа анхааралтай болгоомжтой хандах
- Шувууны гаралтай түүхий эдийг (мөн үхрийн сүү) хагас боловсруулсан байдлаар хэрэглэхгүй байх
- Шувууны аж ахуйд өвчний сэжигтэй, өвчилсөн шувууд бүртгэгдсэн үед: ЗӨСҮТ-н 70282853 дугаарт мэдээлэл өгөх
- Шувууны аж ахуйн орчинд нэвтрэх хүний болон техник хэрэгсэлийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүртгэл хөтлөх
- Төмөр тор, тоног төхөөрөмж, байрны бетон шал болон шалны хөндлөвч, хог зайлуулах суваг, шувууны суултуур, тэжээлийн сав, услууур зэрэгт халдваргүйжүүлэлтийг холбогдох зааврын дагуу хийх
- Өвчний сэжигтэй шувуудыг бусад шувуудаас тусгаарлах, мэрэгч амьтад орж гарах нүхийг битүүлэх
- Нүд улайх болон ханиадны шинж тэмдэг хүнд илрэвэл маск зүүж, эмнэлэгт хандах